



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/218-НА-СТА-ТШЗ

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он</p> | <p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|--|-------|
| 1. Аудитын дүгнэлт..... | 3-4 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 5-9 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 10 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 10 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин..... | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 11 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт..... | 11 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 12-14 |
| 4. Аудитын тайлан..... | 14 |
| 4.1 Ерөнхий зүйл | 14 |
| 4.2 Материаллаг байдал | 15 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..... | 15 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 16 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 16 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 17 |
| 5. Аудитын илрүүлэлт | 17-18 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл | 19-20 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|-----------------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| БШУГ | Боловсрол, шинжлэх ухааны газар |
| ЗГ | Засгийн газар |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ОРХОНТУУЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Т.САРАНЧИМЭГ ТАНАА

2025.02.25 № СЭА-2025/218/НА-СТА-ТШЗ
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 20,035.7 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 2 зорилтын хүрээнд 101 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------|--|-------------------|--------------------|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 158,051,723.77 | 247,606,633.57 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 84,587,163.13 | 131,017,537.23 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 84,587,163.13 | 131,017,537.23 |
| 3121 | Төгрөг | 84,587,163.13 | 131,017,537.23 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 84,587,163.13 | 131,017,537.23 |
| 33 | АВЛАГА | 2,577,172.64 | 1,266,702.64 |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,577,172.64 | 1,266,702.64 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 70,887,388.00 | 115,322,393.70 |
| 351 | Түүхий эд материал | | 38,169,000.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | | 38,169,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 70,887,388.00 | 77,153,393.70 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 2,979,700.00 | 3,154,200.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 38,630,984.03 | 38,630,984.03 |
| 3543 | Сэлбэг хэрэгсэл | 1,620,000.00 | 1,620,000.00 |
| 3546 | Хүнсний материал | 570,500.00 | 3,784,500.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 27,086,203.97 | 29,963,709.67 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,041,522,322.95 | 1,183,479,492.86 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,041,522,322.95 | 1,183,479,492.86 |
| 392 | Биет хөрөнгө | 1,001,855,823.07 | 1,144,125,492.86 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,063,554,400.00 | 1,173,761,800.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (230,931,514.66) | (273,473,690.62) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 14,912,500.00 | 14,912,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (14,912,500.00) | (14,912,500.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 206,438,849.25 | 313,286,974.25 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (103,915,462.82) | (137,144,786.81) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 105,476,203.20 | 119,331,203.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (61,403,299.56) | (72,416,639.20) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 27,236,632.00 | 27,236,632.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (16,050,173.59) | (18,386,506.91) |
| 39217 | Ном | 11,450,189.25 | 11,930,506.95 |
| 393 | Биет бус хөрөнгө | 39,666,499.88 | 39,354,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,187,500.12) | (1,500,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 39,354,000.00 | 39,354,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,199,574,046.72 | 1,431,086,126.43 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 2,227,072.00 | 19,084,500.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,227,072.00 | 19,084,500.00 |
| 413 | Өглөг | 2,227,072.00 | 19,084,500.00 |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2,227,072.00 | |
| 4136 | Бусад өглөг | | 19,084,500.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 19,084,500.00 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,197,346,974.72 | 1,412,001,626.43 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,197,346,974.72 | 1,412,001,626.43 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 596,019,208.20 | 596,019,208.20 |
| 51101 | Өмч: - төрийн | | |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (603,759,639.95) | (389,104,988.24) |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | (603,759,639.95) | (603,759,639.95) |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 214,654,651.71 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,205,087,406.47 | 1,205,087,406.47 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,199,574,046.72 | 1,431,086,126.43 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------|--|------------------|------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,143,057,242.06 | 1,723,257,611.37 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 58,137,358.50 | 258,913,348.40 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 58,137,358.50 | 258,913,348.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,474,238.00 | 20,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,572,000.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,902,238.00 | 20,000,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 35,586,121.50 | 226,715,842.70 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 19,076,999.00 | 12,197,505.70 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,084,919,883.56 | 1,464,344,262.97 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 901,622,800.00 | 1,281,157,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 901,622,800.00 | 1,281,157,900.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 183,297,083.56 | 183,186,362.97 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 183,297,083.56 | 183,186,362.97 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,102,789,495.20 | 1,508,602,959.66 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,102,789,495.20 | 1,508,602,959.66 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,064,649,129.20 | 1,470,234,375.66 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 647,471,483.28 | 977,791,277.96 |
| 210101 | Үндсэн цалин | 473,709,862.00 | 605,339,257.58 |
| 210102 | Нэмэгдэл | 140,319,903.28 | 343,748,106.00 |
| 210104 | Урамшуулал | 33,441,718.00 | 28,703,914.38 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 81,460,910.35 | 119,815,282.69 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,679,152.07 | 82,103,614.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,421,354.76 | 9,622,500.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,097,543.77 | 4,781,127.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,205,631.25 | 4,545,409.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,057,228.50 | 18,762,631.01 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 177,544,383.56 | 175,531,762.97 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,610,268.33 | 12,027,745.54 |
| 210302 | Түлш, халаалт | 161,652,395.23 | 162,022,297.43 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,281,720.00 | 1,481,720.00 |
| 2105 | Нормативт зардал | 34,457,880.00 | 36,550,970.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,457,880.00 | 36,550,970.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,752,700.00 | 7,654,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,752,700.00 | 7,654,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,210,771.06 | 10,684,535.95 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,572,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,638,771.06 | 10,684,535.95 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 112,751,000.95 | 142,205,946.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,332,657.00 | 44,324,873.30 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,667,700.00 | 8,447,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 80,750,643.95 | 89,433,672.79 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 38,140,366.00 | 38,368,584.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 38,140,366.00 | 38,368,584.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 26,838,466.00 | 25,345,384.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,301,900.00 | 13,023,200.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 40,267,746.86 | 214,654,651.71 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 40,267,746.86 | 214,654,651.71 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------|--|------------------|------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,088,394,121.56 | 1,484,344,262.97 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,474,238.00 | 20,000,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 3,474,238.00 | 20,000,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,474,238.00 | 20,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,572,000.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,902,238.00 | 20,000,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,084,919,883.56 | 1,464,344,262.97 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 901,622,800.00 | 1,281,157,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 901,622,800.00 | 1,281,157,900.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 183,297,083.56 | 183,186,362.97 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 183,297,083.56 | 183,186,362.97 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,021,692,749.25 | 1,433,238,888.87 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,021,692,749.25 | 1,433,238,888.87 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 983,559,851.25 | 1,394,733,304.87 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 648,781,953.28 | 976,480,807.96 |
| 210101 | Үндсэн цалин | 472,167,212.00 | 601,806,571.58 |
| 210102 | Нэмэгдэл | 143,173,023.28 | 345,970,322.00 |
| 210104 | Урамшуулал | 33,441,718.00 | 28,703,914.38 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 81,460,910.35 | 119,815,282.69 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,679,152.07 | 82,103,614.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,421,354.76 | 9,622,500.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,097,543.77 | 4,781,127.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,205,631.25 | 4,545,409.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,057,228.50 | 18,762,631.01 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 177,544,383.56 | 175,531,762.97 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,610,268.33 | 12,027,745.54 |
| 210302 | Түлш, халаалт | 161,652,395.23 | 162,022,297.43 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,281,720.00 | 1,481,720.00 |
| 2105 | Нормативт зардал | 32,808,776.00 | 41,855,042.00 |
| 210502 | Хоол, хүнс | 32,808,776.00 | 41,855,042.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,752,700.00 | 7,654,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,752,700.00 | 7,654,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,210,771.06 | 10,578,201.95 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,572,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,638,771.06 | 10,578,201.95 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,000,357.00 | 62,817,607.30 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,332,657.00 | 54,370,207.30 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,667,700.00 | 8,447,400.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 38,132,898.00 | 38,505,584.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 38,132,898.00 | 38,505,584.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 26,830,998.00 | 25,482,384.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,301,900.00 | 13,023,200.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 66,701,372.31 | 51,105,374.10 |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | | |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 22,000,000.00 | 4,675,000.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 22,000,000.00 | 4,675,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 22,000,000.00 | 4,675,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (22,000,000.00) | (4,675,000.00) |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 44,701,372.31 | 46,430,374.10 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 84,587,163.13 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 131,017,537.23 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | | |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | | |
| 8 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 596,019,208.20 | 1,205,087,406.47 | (603,759,639.95) | 1,197,346,974.72 |
| 9 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 10 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 11 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 12 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 13 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 14 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| 15 | Тайлант үеийн үр дүн | | | 214,654,651.71 | 214,654,651.71 |
| 16 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 596,019,208.20 | 1,205,087,406.47 | (389,104,988.24) | 1,412,001,626.43 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/ | Хувь |
|---------|--|------------------|-----------------------------|--------------------------------------|-------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,602,732,200.00 | 1,437,913,888.87 | 164,818,311.13 | 90.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,602,732,200.00 | 1,433,238,888.87 | 169,493,311.13 | 89.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,561,534,700.00 | 1,394,733,304.87 | 166,801,395.13 | 89.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,059,386,900.00 | 976,480,807.96 | 82,906,092.04 | 92.2 |
| 210101 | Үндсэн цалин | 669,525,800.00 | 601,806,571.58 | 67,719,228.42 | 89.9 |
| 210102 | Нэмэгдэл | 359,337,700.00 | 345,970,322.00 | 13,367,378.00 | 96.3 |
| 210104 | Урамшуулал | 30,523,400.00 | 28,703,914.38 | 1,819,485.62 | 94.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 132,423,500.00 | 119,815,282.69 | 12,608,217.31 | 90.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 90,048,000.00 | 82,103,614.28 | 7,944,385.72 | 91.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,593,900.00 | 9,622,500.52 | 971,399.48 | 90.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,296,900.00 | 4,781,127.51 | 515,772.49 | 90.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,296,900.00 | 4,545,409.37 | 751,490.63 | 85.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,187,800.00 | 18,762,631.01 | 2,425,168.99 | 88.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 209,807,500.00 | 175,531,762.97 | 34,275,737.03 | 83.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 18,436,400.00 | 12,027,745.54 | 6,408,654.46 | 65.2 |
| 210302 | Түлш, халаалт | 188,771,700.00 | 162,022,297.43 | 26,749,402.57 | 85.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,599,400.00 | 1,481,720.00 | 1,117,680.00 | 57.0 |
| 2105 | Нормативт зардал | 49,118,700.00 | 41,855,042.00 | 7,263,658.00 | 85.2 |
| 210502 | Хоол, хүнс | 49,118,700.00 | 41,855,042.00 | 7,263,658.00 | 85.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,892,600.00 | 7,654,600.00 | 238,000.00 | 97.0 |
| 210604 | Урсгал засвар | 7,892,600.00 | 7,654,600.00 | 238,000.00 | 97.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 18,778,700.00 | 10,578,201.95 | 8,200,498.05 | 56.3 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 18,778,700.00 | 10,578,201.95 | 8,200,498.05 | 56.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 84,126,800.00 | 62,817,607.30 | 21,309,192.70 | 74.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 75,677,700.00 | 54,370,207.30 | 21,307,492.70 | 71.8 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,449,100.00 | 8,447,400.00 | 1,700.00 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 41,197,500.00 | 38,505,584.00 | 2,691,916.00 | 93.5 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 41,197,500.00 | 38,505,584.00 | 2,691,916.00 | 93.5 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 28,174,300.00 | 25,482,384.00 | 2,691,916.00 | 90.5 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | 13,023,200.00 | | 13,023,200.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 13,023,200.00 | (13,023,200.00) | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 4,675,000.00 | (4,675,000.00) | |
| | Дотоод эх үүсвэрээр | | 4,675,000.00 | (4,675,000.00) | |
| 222001 | Тоног төхөөрөмж | | 4,675,000.00 | (4,675,000.00) | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,602,732,200.00 | 1,484,344,262.97 | 118,387,937.03 | 97.7 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,281,157,900.00 | 1,281,157,900.00 | - | 100.0 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,281,157,900.00 | 1,281,157,900.00 | - | 100.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | | - | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 217,700,100.00 | 183,186,362.97 | 34,513,737.03 | 84.2 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 217,700,100.00 | 183,186,362.97 | 34,513,737.03 | 84.2 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 20,000,000.00 | 20,000,000.00 | - | 100.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,000,000.00 | 20,000,000.00 | - | 100.0 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 83,874,200.00 | | | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 84,587,163.13 | (84,587,163.13) | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 131,017,537.23 | (131,017,537.23) | |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургууль нь “Хүүхэд бүрд урам зориг, Багш бүрд шилдэг арга зүй, Эцэг эх бүрд сэтгэл ханамж” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үе шаттай, үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах,
- Суралцагчдад суралцахуйн баяр баяслыг мэдрүүлж, бие даасан бүтээлч, хүнлэг сурагчдыг төлөвшүүлж, мэргэжлийн чиг баримжаатай сурагчдыг бэлтгэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 231,512.0 мянган төгрөгөөр буюу 19.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|--------------------|--------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 84,587.2 | 131,017.5 | 46,430.3 |
| Авлага | 2,577.2 | 1,266.7 | (1,310.5) |
| Бараа материал | 70,887.4 | 115,322.4 | 44,435.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,041,522.3 | 1,183,479.5 | 141,957.2 |
| Нийт хөрөнгө | 1,199,574.1 | 1,431,086.1 | 231,512.0 |
| Өр төлбөр | 2,227.1 | 19,084.5 | 16,857.4 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,197,347.0 | 1,412,001.6 | 214,654.6 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,199,574.1 | 1,431,086.1 | 231,512.0 |

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 131,017.5 мянган төгрөг болж 46,430.3 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
2. Авлага дансны үлдэгдэл 1,266.7 мянган төгрөг болж 1,310.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагаас барагдуулсанаас,
3. Бараа материалын дансны үлдэгдэл 115,322.4 мянган төгрөг болж 44,435.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 147,710.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Боловсролын газраас 2,877.5 мянган төгрөгийн сурах бичиг, сумын орон нутгийн хөгжлийн сангаас 9,320.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үйл ажиллагаанд 115,472.9 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас,
4. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,183,479.5 мянган төгрөг болж 141,957.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 4,675.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, аймгийн Боловсролын газраас 12,466.7 мянган төгрөгийн сурах бичиг, ухаалаг телевизор, chromebook, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 86,640.0 мянган төгрөгийн мэдээлэл зүйн кабинетын тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, зөөврийн компьютер, 110,207.4 мянган төгрөгийн дотуур байрны дээврийн засварын ажлыг капиталжуулан бүртгэсэн, Дээрэт олон улсын энэрлийн байгууллагаас 17,401.8 мянган төгрөгөөр сурагчдын chromebook үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авч, тайлант онд 89,433.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалсан байна.
5. Өр төлбөр дансны үлдэгдэл 19,084.5 мянган төгрөг болж 16,857.4 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх өр төлбөрийг барагдуулж, Боловсролын яамны ерөнхий гэрээний дагуу Персон хөтөлбөрийн хүрээнд лизингийн гэрээгээр нийлүүлэгдсэн утасгүй интернэтийн төхөөрөмжийн үлдэгдэл төлбөрөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 865,687.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 183,186.3 мянган төгрөг нийт 1,048,874.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 519,344.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,385,032.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 34,513.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 217,700.1 мянган төгрөгөөр, нийт 1,602,732.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант 2024 онд 9 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 1,281,157.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 217,700.1 мянган төгрөгийн санхүүжилт, ЗД-ын нөөц хөрөнгөөс 10,000.0 мянган төгрөгийн, Дээд шатны төсвөөс 10,000.0 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 83,874.2 мянган төгрөг зарцуулахаар зэрэг төсвийг нийт **1,602,732.2** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, НДШ-ийн зардлыг 448,181.1 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 3,181.6 мянган төгрөгөөр,
- Тогтмол зардлыг 34,275.8 мянган төгрөгөөр,
- Урсгал зардлыг 13,428.0 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 18,778.7 мянган төгрөгөөр,
- Урсгал засварын зардлыг 238.0 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 35,775.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,385,032.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 217,700.1 мянган төгрөг, нийт 1,602,732.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,437,913.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,437,913.9 мянган төгрөг буюу 89.7 хувьтай байгаа нь дотуур байрны зардлыг 54,187.6 мянган төгрөгөөр, бичиг үсгийн боловсролын хөтөлбөрийн зардлыг 8,370.3 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 34,513.7 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 45,683.7 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| Хөтөлбөр, арга хэмжээ | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | /мянган төгрөгөөр/ | |
|-----------------------------------|-----------------------|--------------------|--------------------|------------------|
| | | | Зөрүү | Биелэлт /хувиар/ |
| Улсын төсвөөс санхүүжих | 1,385,032.1 | 1,254,727.5 | 131,017.5 | 90.6 |
| 80226 - Байр ашиглалтын үйлчилгээ | 2,017.0 | 2,016.9 | 0.7 | 100.0 |
| 80233 - Хүүхэд хамгаалал | 2,145.6 | 2,143.7 | 1.9 | 99.9 |

| | | | | |
|---|--------------------|--------------------|------------------|-------------|
| 80312 - Сургалт семинар | 1,476.5 | 1,110.0 | 366.5 | 75.2 |
| 81605 - Эрүүл мэндийг дэмжих | 2,003.6 | 1,962.0 | 41.8 | 97.9 |
| 81801 - Үдийн цай хөтөлбөр | 28,174.3 | 25,482.4 | 2,691.9 | 90.4 |
| 81806 - Дотуур байр | 238,007.5 | 183,820.4 | 54,187.6 | 77.2 |
| 81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 19,801.9 | 19,084.5 | 717.4 | 96.4 |
| 81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх | 6,014.8 | 1,065.6 | 4,949.2 | 17.7 |
| 81827 - Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр | 32,698.0 | 24,327.7 | 8,370.3 | 74.4 |
| 81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 979,607.7 | 934,635.6 | 45,683.7 | 95.4 |
| 81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 50,836.8 | 47,957.4 | 2,879.4 | 94.3 |
| 81875- Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 2,246.8 | 1,121.3 | 1,125.5 | 49.9 |
| 83602 - ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан | 10,000.0 | 10,000.0 | - | 100.0 |
| 83603- Дээд шатны төсвөөс | 10,001.6 | - | 10,001.6 | - |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 217,700.1 | 183,186.4 | 34,513.7 | 84.1 |
| 80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 217,700.1 | 183,186.4 | 34,513.7 | 84.1 |
| ДҮН | 1,602,732.2 | 1,437,913.9 | 165,531.2 | 89.7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургууль хүнсний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

| № | Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал | Батлагдсан төсөв | Гэрээний дүн | Тендер шалгаруулалтын арга |
|---|---|------------------|-----------------|----------------------------|
| 1 | Үдийн цайны материал | 27,769.5 | 27,769.5 | ХТШ |
| 2 | Дотуур байрны хүнс | 45,937.1 | 45,937.1 | ХТШ |
| | Нийт дүн | 73,706.6 | 73,706.6 | |

Уг шалгаруулалтад оролцогч ирээгүй тул УБТЗ-ын Ган зам дэлгүүр, Буянтөргөн туул ХХК, иргэн Ц.Дэлэг, Отгоншиг, Д.Батмэнд нартай гэрээ байгуулан, шууд худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,102,789.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 16,541.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Үүнд: Хугацаа хоцроосон

- Худалдан авах ажилагааны төлөвлөгөө – 1 удаа
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт - 1 удаа
- Байгууллагын батлагдсан төсөв– 1 удаа

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 24/49 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,537.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс төлбөр тооцоог хянаагүйн улмаас ажиллагаадаас авах авлага, хүнсний материалын өр төлбөр үүсгэсэн зөрчилд албан шаардлага, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------------|----------|----------------|--------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | - | | | |
| Албан шаардлага | 1 | 3,537.6 | 1 | 3,537.6 | 100.0 |
| Зөвлөмж | 1 | - | 1 | - | 100.0 |
| Нийт дүн | 2 | 3,537.6 | 2 | 3,537.6 | 100.0 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 21,962.0 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Боловсролын газраас үнэ төлбөргүйгээр хүлээн авсан 1,798.9 мянган төгрөгийн сурах бичгийг бүртгэлд тусгахдаа бөөн дүнгээр бүртгэсэн, 1,078.6 мянган төгрөгийн сурах бичгийг бүртгэл тайланд тусгалгүй орхигдуулсан,
- Юнивишн ХХК-д өгөх 24 сарын хугацаагаар лизингээр нийлүүлэгдэж буй утасгүй интернэтийн сүлжээний тоног төхөөрөмжийн үлдэгдэл 19,084.5 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайланд өр төлбөрөөр тусгаагүй, хөрөнгийг үнэн зөв ангилж бүртгээгүй,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **3,197.0** мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрч 1,797.9 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 1,399.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Б/49 дүгээр тушаалаар сургуулийн захирал Б.Саранчимэгт сахилгын шийтгэл ногдуулсан боловч ур чадварын нэмэгдэлд 1,486.1 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь БШУС, ХНХ, СС-ын сайдын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/35, А/10, 9 дугаар хамтарсан тушаалын 3 дахь “*Багш ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоход дараах нийтлэг шалгуурыг харгалзана*” 3.2-д “*Ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй байх*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ур чадварын нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Улирлын амралттай хугацаанд бус 8 дугаар сард багш нарт анги даалтын нэмэгдэл 311.8 мянган төгрөгийг бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А/376, А/217/366 дугаар *“Журамд өөрчлөлт оруулах тухай”* тушаалын 1 дэх *“Сурагчийн улирлын амралт болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас ерөнхий боловсролын сургууль, сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон боловч багш үндсэн ажлаа гүйцэтгэж байгаа тохиолдолд багшид албан тушаалын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс урамшил олгоно”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон анги даалтын нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөрийн бараа, ажил үйлчилгээний зардлаас томилолтын зардалд 290.0 мянган төгрөгийг, багш ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн зардлаас олимпиад уралдаан тэмцээнд оролцох томилолтын 510.0 мянган төгрөг, нийт 800.0 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан *“Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын”*-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Зайлшгүй шаардлагаар буюу мэргэжлийн багш хүрэлцээгүйн улмаас сургалтын менежерүүдэд долоо хоногт заах тогтоосон хэмжээг хэтрүүлэн хичээл заасан гэх үндэслэлээр 599.1 мянган төгрөгийн нэмэгдэл цалин хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, БШУЯ-ны сайдын 2023 оны А/386 тоот тушаал 1.1 *“Мэргэжлийн багш хүрэлцээгүйн улмаас хичээл, сургалтын тасралтгүй байдал алдагдахад хүрсэн тохиолдолд тухайн сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер болон бусад багш мэргэжилтэй ажилтнаар мэргэжлийн дагуу долоо хоногт 6 хүртэл цагийн хичээл заах нөхцөлийг бүрдүүлж, сургалтын хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэх арга хэмжээ авах”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|------------|-----------------|-----------------------------------|-----------------|--------------------------|----------------|------------|-----------------|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сурах бичгийг бөөн дүнгээр бүртгэсэн, бүртгэлд тусгалгүй орхигдуулсан | 2 | 2,877.5 | 1 | 1,078.6 | 1 | 1,798.9 | 2 | 2,877.5 | | | | |
| Өр төлбөр үүсгэж бүртгээгүй | 1 | 19,084.5 | 1 | 19,084.5 | | | 1 | 19,084.5 | | | | |
| Дүн | 3 | 21,962.0 | 2 | 20,163.1 | 1 | 1,798.9 | 3 | 21,962.0 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|----------------|---------------|----------------|-----------------|----------------|---------|-----|--------------------------------------|-----|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сахилгын шийтгэлтэй байх хугацаанд ур чадварын нэмэгдэл олгосон | 1 | 1,486.1 | 1 | 1,486.1 | | | | | | | | |
| Улирлын амралттай хугацаанд анги даалтын нэмэгдэл бодож олгосон | 1 | 311.8 | 1 | 311.8 | | | | | | | | |
| Зардлын бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан | 1 | 800.0 | | | 1 | 800.0 | | | | | | |
| Сургалтын менежерийн хичээл заах цагийг хэтрүүлсэн | 1 | 599.1 | | | 1 | 599.1 | | | | | | |
| Дүн | 4 | 3,197.0 | 2 | 1,797.9 | 2 | 1,399.1 | | - | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна | 1 | - | | | | | 1 | - |
| Дүн | 1 | | | | | | 1 | |
| Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | - | | | | | 1 | - |